

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ  
ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2020 оны 12 сарын 09

Сайнцагаан сум

№	<b>Хөтөлбөрийн танилцуулга хэсэг</b>	
1	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Дундговь аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2020-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
2	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалт
4	Хэрэгжүүлэгч байгууллага	Биеийн тамир, спортын газар
5	Хэрэгжих нийт хугацаа	3 жил
6	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1.</b> Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр.</p> <p><b>Зорилт 2.</b> Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p> <p><b>Зорилт 3.</b> Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах.</p> <p><b>Зорилт 4.</b> Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр</p> <p><b>Зорилт 5.</b> Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан шинэлэг ажил</p>
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>		
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр.		
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Төсөл, хөтөлбөрийн зорилт:
	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг	<b>Төрийн албаны салбар зөвлөлийн болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг</b>

	сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	<p><b>/ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.</b></p> <p>Төрийн албаны салбар зөвлөлөөс 2020 онд Биеийн тамир, спортын газарт нийтийн албанд томилуулахаар нэрийг нь дэвшүүлсэн этгээд байхгүй болно. <b>ҮБ ХАСУМ-д хавсаргаж хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтийг оруулах.</b></p> <p>Биеийн тамир, спортын газарт сул ажлын байрны орон тоо гараагүй болно. <b>ҮБ Нийтийн албанд шинээр томилогдсон этгээдийн ХАСХОМ-ийг 30 хоногт хүлээн авч баталгаажуулах.</b></p> <p>Биеийн тамир, спортын газарт шинээр албан хаагч томилогдоогүй болно. <b>ҮБ Нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.</b></p> <p>Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйл 46,1 дэх заалтын дагуу албан тушаалаас чөлөөлөгдсөн албан хаагч байхгүй болно. <b>ҮБ Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг судлан, гүйцэтгэлийн үнэлгээ хийх.</b></p> <p>Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, үнэлэх арга зүй сэдэвт сургалтыг нийт албан хаагчдад явуулж журмын дагуу үнлэгээ хийж байна. <b>100%</b></p>
	4.1.1.7. нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	<p><b>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.</b></p> <p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно. Байгууллагын дотоод хяналтын баг төлөвлөгөөний дагуу хяналт хийж ажиллаж байна. <b>100%</b></p>
	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	<p><b>Авлигын эсрэг хууль тогтоомжийн сургалтанд төрийн албан хаагчдыг хамруулах.</b></p> <p>Covid-19-ын халдвар дэлхий нийтээр цар тахал хэлбэрээр дэгдэж байгаатай холбогдуулан Улсын онцгой комиссын шийдвэрээр спорт заалны болон спортын уралдаан тэмцээн, сургалт зохион байгуулахыг хориглосон.</p>
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр		
	4.1.2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	<p><b>Төрийн зарим ажил үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, үйлчилгээг ил тод, нээлттэй болгох.</b></p> <p>Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд өөрийн бие бялдрын хөгжлийн түвшин ямар байгаа эсэх талаар “Sport gov.mn” Биеийн тамир, спортын газарын цахим хаягаар орж мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Мөн Улсын шүүгч болон Олон улсын</p>

<p>4.1.2.5. Төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах.</p> <p>4.1.2.6. өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах</p>	<p>хэмжээний мастер спортын мастер цолтой тамирчдын мэдээллийг цахим хэлбэрээр харах боломжтой болсон байна.</p> <p style="text-align: right;"><b>100%</b></p> <p><b>Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах.</b></p> <p>Албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнсэн. Байгууллагын нийт 12 ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэхэд: дэмжлэгт удирдлага 80% нь сайн, 20% нь дунд, хүний нөөцийн хөгжих боломж 92% нь сайн, 8% нь дунд, байгууллагын соёл 83.5% нь сайн, 16.5% нь дунд, ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчин 30% нь сайн, 70% нь дунд гэсэн үнэлгээ гарч Ерөнхий сэтгэл ханамж: сайн-71.4%, дунд-28.6% гэсэн судалгааны дүн гарсан. Байгууллагын ажилчдын сэтгэл ханамжийн асуулгын дүнгийн дагуу доорх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Ерөнхий сэтгэл ханамж: сайн-91.3%, дунд-8.7% болж өссөн байна.</p> <p><b>100%</b></p> <p><b>Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах журмыг шинэчлэн боловсруулж, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.</b></p> <p>2020 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс эхлэн одоог хүртэл албан ёсны цахим хуудсаар иргэдээс Биеийн тамир, спортын газарт хандсан өргөдөл, гомдол ирээгүй болно.</p> <p><b>100%</b></p>
<p>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах.</p>	
<p>4.1.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлага-тай байх зарчмыг мөрдүүлэх.</p> <p>4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах</p> <p>4.1.3.7. аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах</p>	<p><b>Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх.</b></p> <p>Байгууллагын өмч хамгаалах комисс байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн тооллогыг 6 дугаар сард хийж эд хөрөнгийг бүрэн картжуулаад байна. Мөн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалтай танилцан ашиглагдахгүй эвдэрч хэмхэрсэн үндсэн хөрөнгүүдийг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 30 дугаар тогтоолын дагуу цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийн анхны өртөг 13,976,660<sup>15</sup> (Арван гурван сая есөн зуун далан зургаан мянга зургаан зуун жар) төгрөг (арван тав) мөнгө, хуримтлагдсан элэгдэл 11,090,392<sup>62</sup>(Арван нэгэн сая ерэн мянга гурван зуун ерэн хоёр) төгрөг (жаран хоёр) мөнгө, үлдэгдэл өртөг 2,886,267<sup>53</sup>(Хоёр сая найман зуун наян зургаан мянга хоёр зуун жаран долоо)төгрөг (тавин гурав) мөнгөний үндсэн хөрөнгийг акталуулахаар орон нутгийн өмчийн албанд санал хүргүүлсэн.</p> <p><b>100%</b></p> <p><b>“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга нь олон нийтэд ойлгомжтой байх.</b></p>

		<p>Биеийн тамир, спортын газар нь 2020 онд shilendans.gov.mn сайтад нийт 111 мэдээ, мэдээллийг оруулж, иргэд олон нийтэд мэдээллийг нээлттэй хүргэж ажилласан. Үүнд: Байгууллагын үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, тэмцээн уралдааны зардал, тушаал, шийдвэр, санхүүгийн тайлан мэдээ, 5.0 сая төгрөгөөс дээшхи гүйлгээ, байгууллагын гэрээ, 2020 оны батлагдсан төсөв, 2021 оны төсөв, аудитын дүгнэлт, хөрөнгө оруулалт гэх мэт. <b>100%</b></p> <p><b>Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулах.</b></p> <p>Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ 2020 онд хэргэжээгүй болно. ҮБ</p> <p><b>Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүний зарцуулалтыг мэдээлэх.</b></p> <p>Төрийн байгууллага нь хуулийн этгээдэд болон хувь хүнээс хандив тусламж авахыг хориглно гэсэн залтын дагуу 2020 онд тусламж хандив аваагүй болно. 100%</p> <p><b>Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</b></p> <p>Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтыг ажлынхаа төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж ажиллаж байна. 100%</p> <p><b>Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох.</b></p> <p>Иргэн, хуулийн этгээдэд болон захиргааны байгууллагад учруулсан хохирол гараагүй болно. 100%</p>
<p>Дөрөв. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр</p>		
	<p>4.1.7.1. Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд судалгаатай ажиллах.</p>	<p><b>Удирдах албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргаж ил тод, нээлттэй мэдээлэх</b></p> <p>Удирдах албан тушаалтны хамаарал бүхий этгээдийн судалгааг гаргаж аймгийн хууль эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. 100%</p>
<p>Тав: Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан шинэлэг ажил</p>		

тамир, спортын газрын фэйсбүүк хуудаснаа байршуулан ажилласан. 100%  
 “Авлигагүй шударга нийгмийн төлөө” уриалгыг хэрэгжүүлэн, авлигын эсрэг ОУ-ын өдрийг албан хаагчдын дунд зохион байгуулан, авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах.  
 2020 оны 9 сарын 10-18-ний өдрүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарын ашиглах талаар иргэдэд 4 төрлийн тараах материалыг 44 ширхэг хувьлан тарааж, 15 богино хэмжээний шторкыг Биеийн тамир, спортын газрын фэйсбүүк хуудаснаа байршуулан дундговь аймгийн цахим хуудаснуудад түгээн ажилласан. 100%

Дүгнэлт дутагдал, асуудлууд (ололт, анхаарах) - Аймгийн Засаг даргаас санаачлан хэрэгжүүлсэн “Авлигагүй, шударга нийгмийн төлөө хамтдаа” уриалгад нэгдсэн.  
 -“Би авлига өгөхгүй, авахгүй” уриатай мандатыг хэвлүүлж, спортын уралдаан тэмцээнд тараахаар төлөвлөн ажиллаж байна.  
 -Газрын даргын хамаарал бүхий этгээдүүдийн судалгааг гаргаж, ХЭЗХэлтэсд хүргүүлсэн.  
 -Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласнаар хамтын ажиллагаа сайжирч, аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэхэд нэг ойлголттой болж, үйл ажиллагаагаа ил тод нээлттэй болгосон.

Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		5	70%	100%	100%	100%	100%
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ			Нэгдсэн үнэлгээ 94%				

ТАЙЛАНГ ХЯНАСАН:  
 ДАРГА:  
 ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:



М.НАРАНБАДРАХ  
 Б.ДАШБИЛЭГ